


Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн  
А/20 дугаар тушаалын наймдугаар хавсралт



№ 2024-001-08

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ, ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦ,  
АХЦС, УУЛ УУРХАЙ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАЙГУУЛЛАГЫН БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гамшиг осол, гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг хяналт шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, ахцс, уул уурхай баяжуулах үйлдвэрийн байгууллагын барилга, байгууламжийг хамруулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулсан барилга байгууламжийн 30 хувьд нийслэлийн Онцгой байдлын газар, аймгийн төв 50 хувьд, сум 100 хувьд “Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалт”-ыг Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч, сургалт хариуцсан мэргэжилтэн нартай хамтран зохион байгуулна.

2.9. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.10. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд,  
барилга байгууламжийн нэр

- 3.1. Газрын тосны бүтээгдэхүүний агуулах;
- 3.2. Шингэрүүлсэн шатдаг хийн агуулах;
- 3.3. Шатахуун түгээх станц;
- 3.4. АХЦС.

Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч,  
хугацаа

- 4.1. Нийслэлийн хяналт шалгалтын  
ажлын хэсгийн ахлагч

Нийслэлийн Онцгой байдлын газрын  
Гамшгаас хамгаалах болон Гал  
түймрийн улсын хяналтын  
ахлах байцаагч нар;

Гишүүд

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн  
Гамшгаас хамгаалах болон Гал  
түймрийн улсын хяналтын  
ахлах байцаагч, байцаагч нар

- 4.2. Орон нутгийн хяналт шалгалтын  
ажлын хэсгийн ахлагч

Төв орон нутгийн Онцгой байдлын  
газрын орлогч, урьдчилан сэргийлэх  
тасгийн дарга

Гишүүд

Төв орон нутгийн Онцгой байдлын  
газрын Гамшгаас хамгаалах болон Гал  
түймрийн улсын хяналтын  
ахлах байцаагч, байцаагч нар

4.3. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2024 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой

байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн [inspector.obeg@gmail.com](mailto:inspector.obeg@gmail.com), Ажиллагааны удирдлагын газрын [disaster\\_inspector@nema.gov.mn](mailto:disaster_inspector@nema.gov.mn) цахим хаягаар тус тус ирүүлнэ.

4.5. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар, Ажиллагааны удирдлагын газар тус тус нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар, Ажиллагааны удирдлагын газар тус тус нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж, холбогдох яам агентлагт гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн танилцуулга, мэдэгдэл хүргүүлнэ.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн  
 1/20 дугаар тушаалын есдүгээр хавсралт



..... БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ГАЛЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ  
 ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ

Хүснэгт 1

| № | Аймгийн нэр | Хяналт шалгалтад хамрагдвал зохих объектын тоо | Хамрагдсан объектын тоо | Илрүүлсэн зөрчлийн тоо | Газар дээр нь арилгуулсан зөрчлийн тоо | Хүргүүлсэн баримт бичгийн тоо |          |             |                             | Нээсэн зөрчлийн хэргийн тоо | Эрх хязгаарласан тоо | Торгуулийн шийтгэл /төгрөгөөр/ |                               |             |                               | Тактикийн дадлага, сургалтын тоо | Тархалтын дадлага, сургалтын тоо | Олон нийтэд хүргэсэн хэвлэл мэдээллийн тоо |
|---|-------------|--|-------------------------|------------------------|--|-------------------------------|----------|-------------|-----------------------------|-----------------------------|----------------------|--------------------------------|-------------------------------|-------------|-------------------------------|----------------------------------|----------------------------------|--|
|   |             |  |                         |                        |  | ЗБАШ                          | Мэдэгдэл | Танилцуулга | Үйл ажиллагаа зогсоосон акт |                             |                      | Хуулийн этгээдийн тоо          | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ | Иргэний тоо | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ |                                  |                                  |  |
| 1 |             |  |                         |                        |  |                               |          |             |                             |                             |                      |                                |                               |             |                               |                                  |                                  |  |
| 2 |             |  |                         |                        |  |                               |          |             |                             |                             |                      |                                |                               |             |                               |                                  |                                  |  |

Жич: Батлагдсан удирдамжид тактик, тархалтын дадлага, сургалт зохион байгуулахаар тусгаагүй бол тактик, тархалтын дадлага сургалт гэсэн хүснэгтийг хоосон үлдээж болно.

ТАНИЛЦСАН

..... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
 ..... /цол/ ..... /гарын үсэг/

МЭДЭЭ НЭГТГЭСЭН.

..... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГТУХБ,  
 ..... /цол/ ..... /гарын үсэг/

..... БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ

Хүснэгт 2

| № | Аймгийн нэр | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо | Урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтаар хүргүүлсэн баримт бичгийн тоо |          |                             | Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо | Зөрчил арилгуулахаар хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн зөрчлийн тоо | Баримт бичгийн хүрээнд арилгасан зөрчлийн тоо | Арилгуулсан зөрчлийн хувь | Нээсэн зөрчлийн хэргийн тоо | Хаасан зөрчлийн хэргийн тоо | Эрх хязгаарласан тоо | Торгуулийн шийтгэл /төгрөгөөр/ |                               |             |                               |  |
|---|-------------|--|--|----------|-----------------------------|---|--|---|---------------------------|-----------------------------|-----------------------------|----------------------|--------------------------------|-------------------------------|-------------|-------------------------------|--|
|   |             |  | ЗБАШ   | Мэдэгдэл | Үйл ажиллагаа зогсоосон акт |   |  |   |                           |                             |                             |                      | Хуулийн этгээдийн тоо          | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ | Иргэний тоо | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ |  |
| 1 |             |  |  |          |                             |   |  |   |                           |                             |                             |                      |                                |                               |             |                               |  |
| 2 |             |  |  |          |                             |   |  |   |                           |                             |                             |                      |                                |                               |             |                               |  |

ТАНИЛЦСАН

..... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
..... /цол/ ..... /гарын үсэг/

МЭДЭЭ НЭГТГЭСЭН.

..... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГТУХБ,  
..... /цол/ ..... /гарын үсэг/